



БАТЛАВ.

“ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ
ЗАХИРАЛ
Ч.БАТ-ЭРДЭНЭ


.....

БАТЛАВ.

“ОРЧИД” ХХК-НЫ ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Б.МӨНХБАТ


.....

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2016 он ⁰⁹ сарын ⁰⁶-ний өдөр

№

Улаанбаатар хот

Нэг талаас “Эрүүл мэндийн хөгжлийн төв” /Сүхбаатар дүүрэг, энхтайвны гудамж 1-р хороо, 136 хаягт байрлах/ түүнийг төлөөлөн захирал Ч.Бат-Эрдэнэ (цаашид захиалагч), нөгөө талаас “Орчид” ХХК-ны Баянгол дүүрэг, 15-р хороо, 23-3-125 тоот хаягт байрших/, гүйцэтгэх захирал Б.Мөнхбат (цаашид гүйцэтгэгч) нар (хамтад нь “талууд” гэх) Монгол Улсын Иргэний хуулийг удирдлага болгон дараах гэрээг харилцан тохиролцож байгуулав.

1. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ гэрээгээр Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зохион байгуулагдах Эрдэм шинжилгээний хурал, хүндэтгэлийн хуралд зориулан Гүйцэтгэгч тал нь захиалагчийн бэлтгэн өгсөн лого, загварын дагуу савхин/ арьс/ материалаар шаардлага хангасан бэлэг дурсгалын зүйлс болох түлхүүрийн оосор, үзэгний сав бэлтгэн нийлүүлнэ.

1.2. Захиалагч нь гүйцэтгэсэн ажлыг хүлээн авч, хөлсийг гэрээгээр тохиролцсон хэлбэр хугацаанд төлнө.

2. Талуудын эрх үүрэг

2.1. Захиалагч тал Гүйцэтгэгч талыг үүргээ биелүүлэхэд шаардагдах лого загвар, тоо хэмжээг өгөх;

2.2. Гүйцэтгэгч тал чанар, ажлын шаардлагад нийцсэн бэлэг дурсгалын зүйлс бэлтгэн нийлүүлэх;

2.3. Захиалагч тал гүйцэтгэсэн ажлын цаг хугацаа, үр дүнг харгалзан төлбөрийг төлөх;

2.4. Гүйцэтгэгч нь ажлыг биечлэн гүйцэтгэнэ.

3. Гүйцэтгэх хугацаа

3.1. Гэрээнд өөрөөр заагаагүй бол ажил гүйцэтгэлийн хугацааг урьдчилан тохиролцсоны дагуу гүйцэтгэнэ.


3.2. Гүйцэтгэгч тал ажлыг заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүрвэл энэ тухайгаа Захиалагчид нэн даруй мэдэгдэнэ.

3.3. Ажил гүйцэтгэх ерөнхий хугацаа: 2016 оны 9 сарын 14 ний өдрийг хүртэлх

4. Үнэлгээ ба Төлбөр

4.1. Нэхэмжилж буй төлбөр нь зөвхөн талуудын тохирсон үйлчилгээнд хамаарна.

4.2. Гэрээгээр гүйцэтгэх ажлын нэг бүрийн 6500 төгрөгөөр 200 ширхэг түлхүүрийн оосор, 12500 төгрөгөөр 200 ширхэг үзэг, балны сав бэлтгэх бөгөөд нийт хөлс 3.800.000 /гурван сая найман зуун мянган/ төгрөг, үүнд НӨАТ-ын 10% орсон болно.



4.3. Төлбөрийн **100%** буюу **3 800.000** /гурван сая найман зуун мянга/ төгрөгийг нэхэмжлэл хүлээн авсан өдрөөс хойш ажлын 3 хоногт гүйцэтгэгч талын нэхэмжлэлээр ажлын 3 хоногт багтаж шилжүүлнэ.

4.4. Гэрээгээр гүйцэтгэсэн ажлын хөлсийг “Орчид” ХХК-ны **Төрийн** банкны 34180146901 тоот дансанд шилжүүлнэ.

5. Үүрэг, хариуцлага

5.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлнө.

6. Гэрээ дуусгавар болох, цуцлах

6.1. Гэрээг дараах үндэслэлээр дуусгавар болгоно.

6.1.1. Гэрээний хугацаа дууссан

6.1.2. Талууд харилцан тохиролцсон

6.2. Захиалагч тал эсвэл Гүйцэтгэгч тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.

7. Бусад заалт

7.1. Гэрээг гурван хувь байгуулж, хоёр талын гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

7.2. Гэрээний хугацаа, нөхцөл байдлын талаар өөрчлөлт оруулахаар бол хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

7.3. Хэрэв талуудын хооронд маргаан гарвал талууд үл маргах журмаар шийдвэрлэх ба маргаанаа шийдвэрэж чадахгүйд хүрвэл Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

7.4. Ажил гүйцэтгэх явцад гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж, талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.


ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

ЗАХИРГАА АЖ АХУЙН АЛБАНЫ ДАРГА

Л.ОЮУНЧИМЭГ


.....


Утас:976-70128806

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“ Орчид ” ХХК төлөөлж

Т.Одончимэг

.....


Утас:976- 99015691,976- 99090676